



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/26

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн шилжих үлдэгдэлийн эх үүсвэрээс санхүүжих Хүнсний зах орчмын гадна дулааны шугамын засвар шинэчлэлтийн ажил (Зуунмод, Номт баг) ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Н.Энхсайхан - Зуунмод сумын Засаг даргын орлогч

Гишүүд:

Ц.Нямгарав - Төв аймгийн “Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГазрын инженер

С.Эрдэнэчимэг - Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Д.Дашдаваа - Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

А.Зоригоо - Төв аймгийн Орон нутгийн газрын худалдан авах ажиллагааны албаны дарга

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Н.Энхсайхан)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг чанд баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлэхийг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4122010103